

Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭГЭН ШҮЛЭГТ ЭХИЙН ЦАГ ИЛЭРСЭН ОНЦЛОГ

М.Ууганбаяр, Ч.Нацагдорж<sup>1</sup>

Эхийн уран сайхны цагийн ай нь эхийн агуулгыг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энд эхийг зохиогч тодорхой тохиолдол бүрт ертөнцийн шинэ дүр зургийг бүтээдэг ажээ. Зохиогч өөрийн зорилгоосоо /установка автора/ болоод тухайн орчин нөхцөлд хамаарах эс хамаарах цаг хугацаа орон зайн янз бүрийн тусгай хүрээнд энэхүү дүр зургийг байрлуулж байдаг<sup>2</sup>. З.Я.Тураева бичихдээ “Уран сайхны цаг бол бодит цаг хугацааны шууд тусгал биш. Энэ нь бодит байдлын дүрлэг загвар юм. Үүнд бодит ертөнцийн тусгал/толилог бус, шууд бус, шатчилсан/зохиомол зүйлс/вымысел/ нэгдэн холбогддог. Уран сайхны цаг бодит, хүртэхүйн, бодгалийн цагийн онцлогийн сүлэлдээг тодорхойлон харуулдаг гэжээ.”<sup>3</sup>

Н.Д.Арутюнова цаг хугацааг хүний зам мөрийн болбод цагийн урсгалын гэсэн хоёр загварт хуваагаад хүнд цаг хугацааг хүртэхүйн тусгайлаг эрхтэн үгүй боловч чухамдаа цаг хугацаа хүний сэтгэл зүйн янз маягийг зохион байгуулдаг гэсэн ба “цаг хугацааг хүнээс саланги тусгаар гэхдээ хүн цаг хугацаанаас ангид бус... цаг хугацааны мэдрэхүй байгалийн орчил мөчлөгийн хүртэхүйд үндэслэнэ...сэтгэл зүйн бүтцүүд нь шугаман цаг хугацаатай холбосон байдаг гэж бичжээ.”<sup>4</sup> Б. Явуухулангийн “Хээр хоносон сар” шүлэг бүрий болох, бүтээ тасрах, одод түгэх, шөнөжин, шүүдэр буух, одод шингэх гээд оройноос өглөө хүртэл цаг хугацааг байгалийн сансрын орчлын үелэл нэг хэв маягаар тухайлбал өдөр хоногийн хэсгээр нэрлэснээрээ орчил мөчлөгийн цагийг илтгэсэн байна.<sup>5</sup>

Б.Явуухулангийн “Хээр хоносон сар” шүлгийг ажиглахад цаг хугацааг өвөрмөц байдлаар илтгэсэн цагийн утгатай шүлэг гэдэг нь ойлгомжтой байна. Б.Явуухулангийн “Хээр хоносон сар” шүлэгт цаг хугацааны утгыг шатлалын /градация/ найруулга зүйн маягаар /стилистическая фигура/илрүүлжээ. Шатлалын найруулга зүйн маягийг

Д.Э. Розенталь, М. А. Теленкова нар дараагийн хэсэг бүр нь утга санааны юм уу сэтгэлийн

1. Монгол Улсын Их Сургууль

1. Папина, А.Ф. Текст: его единицы и глобальные категории, М. 2002, 166-р тал

2. Тураева З. Я., Лингвистика текста М., 1986, 87-р тал

3. Арутюнова Н.Д., Время модели и метафоры. Логический анализ языка Язык и время. М., 1997, 52-р тал

4. Цэрэнчимэд Л., Уран сайхны эх бичвэрийн найруулга дахь орон ба цагийн айн харилцан хамаарлын тухайд, 2011, 64-р тал

хөдөлгөөн илэрхийллийн нэмэгдэх ихэсгэх /ховор тохиолд багасгах/ утгыг агуулснаараа төрж буй сэтгэгдлийг ахиулах /ховор тохиолд бууруулах/ үгүүлбэрийн хэсгийн /үг ба өгүүлбэрийн хэсэглэл/байршилд байгаа найруулга зүйн маяг гэж тодрхойлсон ба ахиулах шатлал гэдгээ ахиулах утгын байрлалд байгаа үг гэж бууруулах шатлал гэдгээ бууруулах утгын байрлалд байгаа үг хэмээсэн байна.<sup>6</sup> Мөн хэл шинжлэлийн толь бичигт шатлалыг ахиулал бууруулалыг /климакс антиклимакс, градация восходящая, градация нисходящая/ нэгтгэсэн нэрлэлт гэжээ.<sup>7</sup>

Энэ шүлэгт дараах гурван мөр ахиуллаар дэвших цагийн утгыг илэрхийлсэн байна.

**Бүрий болтол хүлээлээ**

**Бүгээ тасаргал хүлээлээ**

**Одод түгтэл хүлээлээ**

Мөн доорх гурван мөр буурууллаар илэрсэн ухрах цагийн утгыг гаргасан байна.

**Шонөжингөө би хүлээлээ**

**Шүүдэр буутал хүлээлээ**

**Одод шингэтэл хүлээлээ**

Загварчилбал:

**Бүрий болтол хүлээлээ**

**Бүгээ тасаргал хүлээлээ**

**Одод түгтэл хүлээлээ**

**Шонөжингөө би хүлээлээ**

**Шүүдэр буутал хүлээлээ**

**Одод шингэтэл хүлээлээ**

**Хээр хоносон сар** хэмээх ойлголт бол энэ хоёр цагийн дэвших, ухрах цагийн чиглэлийг холбож өгч байгаа шүлгийн туйл хэсэг болж байгаа оргил цаг юм. Нөгөөтэйгүүр сар нь энэхүү шүлэгт гарч байгаа ахиулал буурууллаар илэрсэн цагийн хувьд тоолох цэг, эхлэлийн цэг болж байгаа бөгөөд сартай харьцуулахад дэвшсэн, ухарсан хоёр цагийг илэрхийлж байгаагаараа **харьцангуй цаг** болж байгаа юм. Харин хэлшинжлэлд туйлын цаг гэсэн ойлголт хэлэх үетэй харьцуулахад хэлэх үеийн урд байх буюу өнгөрсөн цаг, хэлэх үетэй зэрэгцэх буюу одоо цаг, хэлэх үеийн хойно байх үе буюу ирээдүй цаг илэрч байна.<sup>8</sup>

**Хэлэх үеийн өмнөх**

**Хэлэх үетэй зэрэгцэх**

**Хэлэх үеийн дараах**

өнгөрсөн

одоо

ирээдүй

5. Розенталь Д. Э. Теленкова М. А., Словарь-справочник лингвистических терминов, М., 1976, 80-р тал

6. Ахманова О.С., Словарь лингвистических терминов М., 1966, 112-р тал

7. Comrie B., Tense Cambridge University Press, 1985, 122-125-р тал

Present E simul S	Одоо Үйл явдал ижил Хэлэх үе
Past E before S	Өнгөрсөн Үйл явдал өмнө Хэлэх үе
Future E after S	Ирээдүй Үйл явдал хойно Хэлэх үе
E-event S	–moment of speech
Relative present E simul R	Харьцангуй одоо Үйл явдал ижил Илгээмжийн цэг
Relative past E before R	Харьцангуй өнгөрсөн Үйл явдал өмнө Илгээмжийн цэг
Relative future E after R	Харьцангуй ирээдүй Үйл явдал хойно Илгээмжийн цэг
E	–event R-reference point

Гэтэл Б.Явуухулангийн шүлэгт сартай харьцуулсан байдлаар илэрч байгаа учраас энэ нь харьцангуй цаг болж байна.

Б. Явуухулангийн энэхүү шүлэгт хүний сэтгэцийн ертөнцийн цаг яригчийн зүгээс “би мэдэж байна, би харж байна, би санаж байна, би хүлээж байна” гэх хэв шинжийн сэтгэхүйн үйл үгийг /ментальные глаголы/ оруулах замаар субъектив сэтгэцийн цагийг үүсгэдэг<sup>8</sup> гэдэгтэй холбох боломжтой юм. Өөрөөр хэлбэл энэ шүлэгт гарч байгаа хүлээлээ гэсэн сэтгэхүйн үйл үг нь тухайн зохиогч үзэгдлүүдийн хоорондын харьцааг өөрийнхөөрөө ойлгон байгаагаа мэдээлдэг зохиогчийн субъектив бодгалийн төсөөллөөр илрэх онцгой цагтай дэлхий ертөнцийн зураг/байгалийн ертөнц, хүний ертөнц/ ч мөн адил бодит байдаг хийгээд энэ нөхцөлд бодит, объектив гадаад байдалтай шууд таарахгүй ч гэлээ цаг хугацаа орон зайд сэлгэхтэй цуг дэлхий ертөнцийг айнуудтай нь цаг хугацаатай нь ойролцоогоор дүрсэлдэг, хувь бодгалийн ертөнцийн зураг нь дэлхийн зүй тогтлыг эвддэггүй учраас бодит гэхдээ субъектив концептуаль цаг гэж нэрлэгдэх цаг хугацааг зааж байгаа хэрэг.

Б. Явуухулангийн энэ шүлгийн зохиомжийн онцлог сонирхолтой шинжийг дурьдах хэрэгтэй. Юуны өмнө уламжлалт эхийн онолд авч үздэг шигээр аливаа эх гарчигаар эхэлж эх гарчигийн ардаас дагалддаг гэдэг үзэл бодлыг энэ шүлгийн цаг хугацааны илэрхийллийг шүлгийн эхээс уншигч ойлгож ухаарсны дараа уул шүлгийн Хээр хоносон сар гэсэн гарчиг нь цагийн утгатай гэдгийг анзаарах боломжтой байгаа гарчгийн утгыг эхийн утга бус, эхийн утгыг гарчгийн утга дагалдаж байна.

8. Папина, А.Ф. Текст: его единицы и глобальные категории. М. 2002, 197-р тал

М.Ууганбаяр, Ч.Нацагдорж

### НОМ ЗҮЙ

1. Арутюнова Н.Д., Время модели и метафоры, Логический анализ языка Язык и время, М., 1997
2. Ахманова О.С., Словарь лингвистических терминов М., 1966
3. Папина, А.Ф. Текст: его единицы и глобальные категории, М, 2002
4. Розенталь Д. Э., Практическая стилистика русского языка, М., 1987
5. Розенталь Д. Э. Теленкова М. А., Словарь-справочник лингвистических терминов, М., 1976
6. Тураева З. Я., Лингвистика текста М., 1986
7. Цэрэнчимэд Л., Уран сайхны эх бичвэрийн найруулга дахь орон ба цагийн айн харилцан хамаарлын тухайд
8. Comrie B., Tense Cambridge University Press. 1985
9. Б.Явуухулан, Түүвэр зохиол, 1977.

### SUMMARY

The authors discuss in this article about time meanings in the poem of Begziin Yavuulhulan. In this poem the poet expresses the meaning of subjective mental time and meaning of cyclic time through the stylistical figure of gradation, climax and anticlimax